

2026 он 5 сар 14 өдөр

Дугаар 1/26/733

Улаанбаатар

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

Хувьцаа эргүүлэн худалдаж авах хөтөлбөрийн тухай

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Ард Даатгал” ХК-ийн 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №04/26 тоот тогтоолоор компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч халааслах тухай шийдвэр гарган баталсан. Энэхүү шийдвэрийн хүрээнд Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийн зорилго нь “Ард Даатгал” ХК-иас олон нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, зах зээлийн ханшийг тогтворжуулах, хувьцааны үнэ цэнийг дэмжих, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад оршино.

Хөтөлбөрийн нөхцөл:

Эргүүлэн худалдаж авах тоо	3,750,000 ширхэг хүртэл (15 хувь хүртэл)
Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнэ	800 төгрөг хүртэл
Эргүүлэн худалдаж авах хугацаа	12 сар
Эргүүлэн худалдаж авах нийт дүн	3,000,000,000 тэрбум төгрөг хүртэл

дээрх нөхцөлүүдийн хүрээнд зах зээлээс үе шаттайгаар худалдан авах бөгөөд энэхүү хөтөлбөр нь компанийн өөрийн хөрөнгийн түвшинг бууруулах зорилго агуулаагүй бөгөөд жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоо, эрх ашгийг дэмжихэд чиглэж байна.

Иймд дээрх хөтөлбөрийг холбогдох журмын хүрээнд бүртгэн авч, хамтран ажиллахыг хүсье.

Та бүхнийг хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н. ЭРДЭНЭТУЛГА

2026 он 4 сар 28 өдөр

Дугаар 04/26

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн хувьцаа эргүүлэн худалдаж авч
хувьцаа халааслах шийдвэр гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь хэсэг, 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №5 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн гаргасан энгийн хувьцааны 15 хувь буюу 3,750,000 ширхэг хүртэл хувьцааг эргүүлэн худалдан авч дараах нөхцөлтэйгээр халааслахаар шийдвэрлэсүгэй.

Эргүүлэн худалдаж авах тоо	3,750,000 ширхэг хүртэл (15 хувь хүртэл)
Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнэ	800 төгрөг хүртэл
Эргүүлэн худалдаж авах хугацаа	12 сар
Эргүүлэн худалдаж авах нийт дүн	3,000,000,000 тэрбум төгрөг хүртэл

2. Хувьцаа эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хувьцаа эргүүлэн худалдаж авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтүлга)-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА




О.ОДБАЯР